

DPUB2
Монгол Улс
дахь ХБИ-ийн
хөдөлмөр
эрхлэлтийг
дэмжих
тогтолцоог
бэхжүүлэх
төсөл

DPUB2 МЭДЭЭ

№ 11
2022 оны Арваннэгдүгээр сар

Малайз улсын туршлага судлах сургалт зохион байгуулагдлаа

DPUB2 төсөл 11-р сарын 7-оос 11-ний өдрүүдэд Малайз улсын туршлага судлах сургалтыг зохион байгууллаа. Малайзын Засгийн газар 2005-2015 оны хооронд ЖАЙКА-тай хамтран техникийн хамтын ажиллагааны төслүүдийг мөн тэр дундаа хөгжлийн бэрхшээлийн салбар амжилттай хэрэгжүүлсэн бөгөөд төсөл дууссаны дараа ч дэмжлэгтэй хөдөлмөр эрхлэлт буюу ажлын байрны дадлагажуулагчийн дэмжих үйлчилгээг тогтвортой хэрэгжүүлж байгаа орон юм.

Иймд тус улсын туршлагыг судлах зорилгоор танилцах сургалтыг зохион байгуулав. Энэхүү сургалтад төр, ТББ-ын төлөөлөл, ажлын байрны дадлагажуулагчийг сургах сургагч багшаар бэлтгэгдэж буй 8 хүн, МҮХАҮТ, Ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, АПУ ХК, Пи Эйч Ар консалтинг ХК гээд нийт 20 хүн оролцсон. Сургалтын эхний өдөр Малайзын Эмэгтэйчүүд, гэр бүл, нийгмийн хөгжлийн яамны удирдлагуудтай уулзаж байна.



Туршлага судлах багийнхан Малайз улсын Эмэгтэйчүүд, гэр бүл, нийгмийн хөгжлийн яамны удирдлагуудтай уулзаж байна.



Аеон (жижиглэн худалдаа) компанийн дэлгүүрт сонсголын бэрхшээлтэй ажилтнууд ямар ямар ажил хэрхэн хийж байгаатай танилцаж байна.

Сургалтын сүүлийн өдөр сургалтад оролцогчид төр, ААНБ, ажлын байрны дадлагажуулагчийг бэлтгэх сургагч багш нар гэсэн 3 багт хуваагдаж, сургалтаас олж авсан мэдлэг туршлагаа Монголд хэрхэн хэрэгжүүлэх талаар санал солилцож, илтгэл тавив. Төслийн зүгээс ойрын хугацаанд Малайз дахь сургалтын тайлангийн хурал болон холбогдох байгууллагуудын хамтын ажиллагааны талаар уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна.



Малайз улсад туршлага судалж, бодит үйл ажиллагаатай танилцсан төр, ТББ, ААНБ-уудын төлөөллүүд Монголд хэрхэн хэрэгжүүлэх талаар танилцуулга хийж байна.

dpub.jica@gmail.com

The Ministry of Labor and Social Protection, 4th khoroo, Chingeltei district, United Nation's street-5, Ulaanbaatar 15160, Mongolia

<https://www.facebook.com/jicadpub1and2>

<https://www.jica.go.jp/project/mongolian/mongolia/030/index.html>